

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАРТ 11-11 ТӨВӨӨС ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 6 ДУГААР САРЫН МЭДЭЭ



2022.07.01

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн харилцааны газарт Засгийн газрын 11-11 төвөөс 1 өргөдөл, хүсэлт ирснийг хүлээн авч “Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн дагуу шийдвэрлэн ажиллалаа.

Өргөдлийн агуулга: Налайх дүүргийн 5 дугаар хороо Гордокын оршин суугч өндөр настан Намсрай. Манай хорооны 74 дүгээр байрыг хувьчлагдана гэсэн боловч хувьчлагдахгүй өдийг хүрч байна. Уг хорооны 74 дүгээр байрыг яаралтай хувьчилж өгөхийг хүсэж байна. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж өгнө үү .

Өргөдөл, гомдол шийдвэрлэлт




Орон сууцны хувьчлалын асуудлыг “Орон сууц хувьчлах тухай хууль”-д заасны дагуу Төрийн Өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны “Журам батлах тухай” 67 дугаар тогтоолоор Орон сууц хувьчлалын товчоогоор дамжуулан шийдвэрлүүлэхээр заасан тул С.Намсрайгийн амьдарч байгаа орон сууцаа хувьчилж авах хүсэлтийг судлан, зохих журмын дагуу шийдвэрлэж өгөх тухай НӨХГ-ын 2022.06.30-ны өдрийн 2/882 дугаартай албан бичгийг Нийслэлийн Орон сууц хувьчлалын товчоо болон иргэн С.Намсрайд хүргүүлсэн.

Д/Д	Санал ирсэн эх үүсвэр	Саналыг үйл ажиллагаандаа тусгах боломжтой эсэх	Иргэний санал	Шийдвэрлэлт
1	/G220617102/ Засгийн газрын 11-11 төв	Боломжгүй	Байр хувьчлах асуудал	Чиг үүргийн бус хүсэлт тул холбогдох байгууллагад албан бичгээр тухайн иргэний хүсэлтийг уламжилсан.

Мэдээллийн ил тод байдал:

Өргөдөл, гомдлын мэдээг 14 хоног тутам гаргаж удирдлагад танилцуулан мэдээллийн самбарт байршуулж байна. Мөн өргөдөл, гомдлын мэдээг олон нийтэд ил тод байлгах хүрээнд байгууллагын цахим сайтад байршуулсан.



Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

1. Засгийн газрын 187 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
2. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг сар бүр байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд ил тод мэдээлж байна.
3. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтэд Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс хяналт, шинжилгээ үнэлгээ хийн ажиллаж байна.